



САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2024-11-01 № 23


Тогтоолын хэрэгжилтийн талаар
асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурал 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр "Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай" 21 дүгээр тогтоол баталсан. Уг тогтоолоор зээлийн хүүг 2019 оны суурь түвшнээс 4 нэгж хувиар бууруулж, 2023 оны эцэст сарын 1 хувьд хүргэхээр хэрэгжилтийг хангаж, хагас жил тутам Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус даалгасан. Гэтэл өнөөдрийн байдлаар манай улсын арилжааны банкуудын зээлийн жигнэсэн дундаж хүү ойролцоогоор 18-аас дээш хувьтай байна. Сүүлийн үед бизнесийн зээл түүний дотор хэрэглээний зээлийн хүү өссөөр байна. Банкны зээлийн хүү өндөр байгаа нь бүтээлч бизнес хөгжих боломж нөхцөлийг хязгаарласаар байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дээр дурдсан Монгол Улсын Их Хурлын 21 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүн, энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээний талаар асуулга тавьж байна.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12.2-т заасан хугацаанд ирүүлнэ үү.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН



Г.ОЧИРБАТ